



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 249, 250 дугаар тогтоолоор батлагдсан журам, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10, 13¹, 13² дахь заалтуудыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10, 13¹, 13² дахь заалтууд:

Заалт	Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь
	Баганын дүн	1	2	3
10	Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%	10%	Нээлттэй сан: 5% Хаалттай сан: 10%
13 ¹	МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	10%	20%
		II ангилал	5%	30%
13 ²	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%	5%	5%

2/ Мөн журмын нэгдүгээр хавсралт “МАЯГТ-1”-д “.....” ХХК-ийн 20...оны дүгээр улирлын зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тооцох аргачлал”-ын 10, 13¹, 13² дахь мөрүүдийг дараах байдлаар өөрчилсүгэй:

000869

Хөрөнгийн ангилал		Хөрөнгө байршуулах дээд хувь	Нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн	Нэгжид ногдох хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь	Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн	Нийт зөвшөөрөгдөхгүй дүн
Заалт	Баганын дүн	1	2	3	4	5	6	7=2+4+6
10	Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%		10%		Нээлттэй сан: 5%		
						Хаалттай сан: 10%		
13 ¹	МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	10%		5%		20%		
						30%		
13 ²	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%		5%		5%		

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 250 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 8, 9 дэх заалтуудыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 8, 9 дэх заалт:

Хөрөнгийн ангилал		Хөрөнгө оруулах дээд хувь
Заалт	Баганын дүн	1
5	Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%
8	МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал
		II ангилал
9	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%


2/ Тус шаардлагын хавсралт “Маягт-1”-ын “Даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгө оруулалтын тайлан”-ийн 5, 8, 9 дэх мөрүүдийг дараах байдлаар өөрчилсүгэй:

Хөрөнгийн ангилал	Даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтын дээд хувь	Даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтын дээд хэмжээ	Даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалт
Баганын дүн	1	2	3
5. Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%		
8. МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	10%	
	II ангилал	5%	
9. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%		

3. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс хойш даатгалын нөөц сангаас үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл олгохыг хориглоно.

4. Дээрх журам, шаардлагад өөрчлөлтүүдийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА